

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/175/НА-СТА-ТШЗ

Баянхонгор аймаг 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhndl@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Аудитын зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022-02-15 № 2/58

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, Г
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
У.БАЛЖИННЯМ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\alban bichig\7-XXAAG 2-34-20220225.docx

005020346

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,020,029.78	125,456,673.09
33	АВЛАГА	4,280,044.52	4,246,977.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,453,044.52	791,343.00
335	Бусад авлага	2,827,000.00	3,455,634.00
3351	Байгууллагаас авах авлага	2,827,000.00	2,827,000.00
33530	Ажилчдаас авах авлага		628,634.00
34	УРЬДЧИЛГАА		7,200,000.0
34600	Урьдчилж гарсан зардал		7,200,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	112,739,985.26	114,009,696.09
351	Түүхий эд материал	41,347,612.96	41,347,612.96
35110	Тусгай зориулалттай материал	41,347,612.96	41,347,612.96
354	Хангамжийн материал	60,721,372.30	66,040,083.13
35410	Бичиг хэргийн материал	3,091,096.00	2,902,596.00
35420	Аж ахуйн материал	41,832,275.00	43,613,215.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,861,400.00	4,861,400.00
35440	Түлш, шатах тослох материал	87,590.30	813,861.13
35450	Барилгын засварын материал	304,425.00	304,425.00
35470	Бусад хангамжийн материал	13,544,586.00	13,544,586.00
35600	Мал амьтад	10,671,000.00	6,622,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	616,714,938.25	606,008,445.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	616,714,938.25	606,008,445.37
392	Биет хөрөнгө	440,389,938.25	431,253,445.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	340,732,740.00	349,700,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,293,810.44)	(42,946,315.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,550,727.00	173,550,727.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(128,687,403.96)	(134,476,219.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110,171,154.51	115,226,847.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,910,941.36)	(56,558,857.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,496,070.85	23,361,095.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,434,786.19)	(14,969,907.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,276,188.00	22,483,854.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,510,000.16)	(4,118,729.32)
393	Биет бус хөрөнгө	176,325,000.00	174,755,000.04
39301	Програм хангамж	7,780,000.00	7,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,380,000.00)	(4,949,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	171,925,000.00	171,925,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	733,734,968.03	731,465,118.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	78,393.00	1,370,994.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	78,393.00	1,370,994.00
413	Өглөг	78,393.00	1,370,994.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	20,493.00	1,313,094.00
4136	Бусад өглөг	57,900.00	57,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	57,900.00	57,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	733,656,575.03	730,094,124.47
51	Засгийн газрын хувь оролцоо	733,656,575.03	722,894,124.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,909,074.85	448,909,074.85
51101	Өмч: - төрийн	448,909,074.85	448,909,074.85

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	200,260,702.28	195,371,651.72
51210	Өмнөх үеийн үр дүн	200,260,702.28	200,260,702.28
51220	Тайлант үеийн үр дүн		(4,889,050.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,486,797.90	85,813,397.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>733,734,968.03</u>	<u>731,465,118.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	896,528,221.07	670,567,877.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	457,241,931.98	176,937,917.26
120	Нийтлэг татварын бус орлого	457,241,931.98	176,937,917.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	457,241,931.98	176,937,917.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/		26,815,967.11
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/		150,121,950.15
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	455,741,931.98	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	439,286,289.09	493,629,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	432,337,600.00	446,203,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	432,337,600.00	446,203,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,948,689.09	47,426,460.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	47,426,460.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	748,689.09	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	562,907,861.89	525,456,927.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,907,861.89	525,456,927.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	562,737,368.89	451,285,296.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,153,700.00	210,245,906.80
210101	Үндсэн цалин	135,099,525.00	149,084,402.00
210102	Нэмэгдэл	39,890,875.00	45,932,584.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,163,300.00	5,118,851.00
210104	Урамшуулал	-	10,110,069.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,320,800.00	26,062,613.38
210201	Тэтгэврийн даатгал	17,114,600.00	18,397,434.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,801,600.00	2,047,701.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,300.00	1,638,161.34
210204	Ажилгүйдлийн даатгал	360,300.00	387,524.27
210205	Эрүүл мэндийн даатгал	3,603,000.00	3,591,791.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,826,278.00	19,662,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,136,100.00	2,353,300.00
210302	Түлш, халаалт	12,186,454.00	14,988,376.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,724.00	2,321,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,902,792.76	38,035,664.32
210401	Бичиг хэрэг	6,442,894.00	8,358,350.15
210402	Тээвэр, шатахуун	13,246,669.78	21,767,929.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,713,800.00	2,625,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,300.00	33,800.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,057,128.98	1,201,085.00
210408	Бараа материал акталсны зардал	2,400,000.00	4,049,000.00
2105	Нормативт зардал	705,500.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	260,700.00	-
210502	Хоол, хүнс	283,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	161,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	800,000.00
210604	Урсгал засвар	-	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,733,000.00	1,524,500.00
210702	Дотоод албан томилолт	3,733,000.00	1,524,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	168,667,077.24	111,842,052.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,724,877.24	107,013,660.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,000.00	203,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	406,200.00	347,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,428,220.89	43,111,659.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,590,510.82	1,598,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,837,710.07	41,513,659.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,493.00	74,171,631.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	72,075,475.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	70,875,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	1,199,975.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,493.00	2,096,156.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,493.00	2,096,156.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	333,620,359.18	145,110,949.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	450,590,816.31	150,000,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	450,590,816.31	150,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(450,590,816.31)	(150,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(116,970,457.13)	(4,889,050.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	440,786,289.09	493,629,960.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,500,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,500,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	439,286,289.09	49,362,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	432,337,600.00	44,620,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	432,337,600.00	44,620,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,948,689.09	4,742,460.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,742,460.00



Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	748,689.09	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	433,286,289.09	490,965,360.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,286,289.09	490,965,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,947,796.09	416,139,303.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,153,700.00	208,865,468.32
210101	Үндсэн цалин	135,099,525.00	15,2649,141.52
210102	Нэмэгдэл	39,890,875.00	41,239,406.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,163,300.00	4,866,851.00
210104	Урамшуулал	0.00	10,110,069.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,320,800.00	26,117,383.34
210201	Тэтгэврийн даатгал	17,114,600.00	18,389,812.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,801,600.00	2,046,936.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,300.00	1,637,566.06
210204	Ажилгүйдлийн даатгал	360,300.00	367,543.16
210205	Эрүүл мэндийн даатгал	360,300.00	3,675,525.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,813,800.00	19,662,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,136,100.00	2,353,300.00
210302	Түлш, халаалт	13,173,976.00	14,988,376.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,724.00	2,321,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,294,400.00	12,125,400.00
210401	Бичиг хэрэг	2,627,800.00	2,137,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,768,900.00	6,624,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,206,300.00	2,625,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,300.00	33,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,649,100.00	704,400.00
2105	Нормативт зардал	7,161,700.00	524,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,161,700.00	524,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,854,200.00	4,958,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,700.00	0.00
210604	Урсгал засвар	2,723,500.00	4,958,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,733,000.00	1,524,500.00
210702	Дотоод албан томилолт	3,733,000.00	1,524,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,616,196.09	138,360,452.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,673,996.09	126,332,060.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,000.00	203,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	406,200.00	347,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,338,493.00	74,826,056.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,318,000.00	72,729,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	70,875,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,318,000.00	1,854,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,493.00	2,096,156.34

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,493.00	2,096,156.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,500,000.00	2,664,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,500,000.00	2,664,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,500,000.00	2,664,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,500,000.00	2,664,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,500,000.00	,2664,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,500,000.00	-2,664,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	317,231,159.63	850,627,032.38
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	317,231,159.63	850,627,032.38
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-116,970,457.13	-116,970,457.13
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.50	733,656,575.25
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.50	733,656,575.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.50	733,656,575.25
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.28	733,656,575.03
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	1,326,600.00	0.00	1,326,600.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,889,050.57	-4,889,050.57
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	730,094,124.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	446,203,500.00	444,107,343.66	2,096,156.34	99.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,203,500.00	444,107,343.66	2,096,156.34	99.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,473,600.00	371,377,443.66	2,096,156.34	99.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,880,200.00	208,865,468.32	14,731.68	99.99
210101	Үндсэн цалин	156,295,700.00	152,649,141.52	3,646,558.48	97.67
210102	Нэмэгдэл	41,175,900.00	41,239,406.00	-63,506.00	100.15

Аудитын код **БНА-2022/175/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,077,000.00	4,866,851.00	210,149.00	95.86
210104	Урамшуулал	6,331,600.00	10,110,069.80	3,778,469.80	159.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,198,800.00	26,117,383.34	2081416.66	92.62
210201	Тэтгэврийн даатгал	19,843,600.00	18,389,812.72	1,453,787.28	92.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,088,800.00	2,046,936.22	41,863.78	98.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,671,000.00	1,637,566.06	33,433.94	98.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,800.00	367,543.16	50,256.84	87.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,177,600.00	3,675,525.18	502,074.82	87.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,662,900.00	19,662,900.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,353,300.00	2,353,300.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	14,988,400.00	14,988,376.00	24.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,321,200.00	2,321,224.00	-24.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,125,400.00	12,125,400.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,137,100.00	2,137,100.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	6,624,600.00	6,624,600.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,625,500.00	2,625,500.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,800.00	33,800.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	704,400.00	704,400.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	524,800.00	524,800.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	524,800.00	524,800.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,623,000.00	7,623,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,664,600.00	2,664,600.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	4,958,400.00	4,958,400.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,524,500.00	1,524,500.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,524,500.00	1,524,500.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,934,000.00	90,933,992.00	8.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,905,600.00	78,905,600.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	600,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,600.00	203,592.00	8.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	347,800.00	347,800.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,729,900.00	72,729,900.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,729,900.00	72,729,900.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,875,500.00	70,875,500.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,854,400.00	1,854,400.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	446,203,500.00	444,107,343.66	2,096,156.34	99.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	446,203,500.00	444,107,343.66	2,096,156.34	99.53
131001	Улсын төсвөөс санхүүжих	446,203,500.00	444,107,343.66	2,096,156.34	99.53
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	21.00	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14.00	14.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,948,689.09	47,426,460.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,948,689.09	47,426,460.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,948,689.09	47,426,460.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,948,689.09	47,426,460.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,948,689.09	47,426,460.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,948,689.09	47,426,460.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,948,689.09	47,426,460.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,426,460.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	748,689.09		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн даргаар ажиллаж байсан Ж.Баттөр 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүртэл, У.Балжинням 2021.12.14-ны өдрөөс эхлэн, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнх-Оргил нар зурж байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэр төрөл чанарыг сайжруулах, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Тайлант онд 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 434,393.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаарх төр, засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, малчид, тариаланчид, иргэдийг мэдээ, мэдээлэл, мэргэжил, арга зүй, технологийн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-385 дугаартай тушаалаар баталсан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ХХААХҮЯ-ны дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 562,907,9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,443,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу мянган 5,910.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 5,517.3 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,469.8 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,020.0	124,828.0	7,808.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,280.0	3,618.3	(661.7)
Урьдчилж гарсан зардал	-	7,200.0	7,200.0
Бараа материал	112,740.0	114,009.7	1,269.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	616,714.9	606,008.4	(10,706.5)
Үндсэн хөрөнгө	832,931.9	864,028.5	31,096.6
Хуримтлагдсан элэгдэл	(216,216.9)	(258,020.0)	(41,803.1)
Нийт хөрөнгө	733,735.0	730,836.5	(2,898.5)
Өр төлбөр	78.4	1,371.0	1,292.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	733,656.6	730,094.1	(3,562.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	733,735.0	731,465.1	(2,269.8)

Дансны авлага өмнөх оноос 661.7 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдад олгосон үр дүнгийн урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүйгээс 628.6 мянган төгрөгийн алдааг залруулсантай холбоотой байна. Мөн системийн хэмжээнд санхүү, төсвийн төслийн программын үнийг урьдчилан шилжүүлсэнээс 7,200.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 114,009,7 мянган төгрөг болж 1,269,7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 36,802.8 мянган, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй нийлүүлсэн оготоно устгалын бэлдмэл 150,000.0 мянган төгрөгийн материалыг бэлтгэсэн, 185,655.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд аж ахуйн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,780.9 мянга, сэлбэг хэрэгслийн дансны үлдэгдэл 3,000.0 мянга, түлш шатах тослох материал 726.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалд голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 864,028,5 мянган төгрөг болж 31,096,6 мянган төгрөгөөр өссөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021.05.20-ны өдрийн А-145 дугаартай тушаалаар үнэ төлбөргүй шилжүүлсэн 27,105.5 мянга, төсвийн хөрөнгөөр авсан 2,664.6 мянга, дахин үнэлгээ хийж орлого авсан 1,326.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, барилга байгууламж, тоног төхөөрөмж бүртгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийгдээгүй байна.

Ажиллагсадтай холбоотой өглөгийн данс өмнөх оноос 1,292.6 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад олгосон үр дүнгийн урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүйгээс 628,6.4 мянган төгрөгийн алдааг залруулсантай холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 730,094.1 мянган төгрөг болж 3,562.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 3,562.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,188,682,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,188,682,3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 769,238.8 мянган төгрөгөөр бууруулж 419,443.5 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газраас 2021 онд 3 удаа тодотгол хийж 446,203.5 мянган төгрөг болж 26,760.0 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 446,203.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 444,107.3 мянган төгрөгийг зарцуулж, 2,096.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас нэмэлт санхүүжилтийн дансанд 47,426.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 41 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 525,456.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 37,451.0 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 493,629.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 454,325.6 мянган төгрөгийн 145 мэдээллийг хугацаанд нь, 39,304.4 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

Аудитын код **БНА-2022/175/НА-СТА-ТШЗ**

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	95	1	
	Нийт	27	151	145	4	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд улсын төсвөөс 446,203.5 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 444,107.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 2,096.2 мянган төгрөг буюу төсвийн 4.7 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 22,194,2 мянган төгрөгөөр, тодотголоор 19,946.1 мянган төгрөгөөр буруулан баталж санхүүжилтийг 2,248.1 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 57,545.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс 220.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 14,647.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 43,676.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2021.06.17-ний өдрийн 1/208 дугаартай албан бичгээр ирүүлж биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын төлөвлөлтийг анхан шатны баримттай тулгалт хийж баталгаажуулах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 164,724.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 628.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 139,025.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,313.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23,758.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллагын даргын 2021.12.22-ны өдрийн Б/61 дугаартай тушаалаар ажилчдад олгосон 5,582.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалингаас НДШ-ийн 628.6 мянган төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

Аудитын код **БНА-2022/175/НА-СТА-ТШЗ**

13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд ажилчдаас авах авлагаар 628.6 мянган төгрөгийг тусгуулж тайланг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын даргын 2021.12.22-ны өдрийн Б/61 дугаартай тушаалаар ажилчдад олгосон 5,582.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг нийгмийн даатгалын санд мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад олгосон 5,582.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст нөхөн мэдээлж, нийгмийн даатгалын шимтгэлийн 1,313.1 мянган төгрөгийн өглөгийг дээрх байгууллагад төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2018 онд дахин үнэлсэн 6,877м2 талбай бүхий 171,295.0 мянган төгрөгийн өртөгтэй газраас 5,561м2 газар буюу 139,025.0 мянган төгрөгийн газрыг Мал эмнэлэгийн газарт шилжүүлж тухайн байгууллага эрхийн улсын бүртгэлийн Э-0320000693 дугаарт бүртгэсэн төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан байтал газрыг шилжүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Журам шинэчлэн батлах тухай" журмын тавдугаар зүйлд заасан заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аймгийн Мал эмнэлэгийн газарт олгосон 5,561м2 газрыг балансаас балансад шилжүүлэх асуудлыг дээрхи журамд заасны дагуу холбогдох баримт материалыг бүрдүүлэн ТӨБЗГ-т хандаж асуудлыг шийдвэрлүүлэхээр албан шаардлага хүргүүлэв.

4.4 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1. Байгууллагын даргын 2021.03.25-ны өдрийн "Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж" олгох тухай "Б/14 дугаартай тушаалаар Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолын шалгуур нөхцөлийн бүрэн хангаагүй байхад мал үржлийн албаны дарга Ч.Чимэг-Очирт 23,758.0 мянган төгрөгийн тэтгэмжийг 2021.03.29-ны өдөр олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2. "Эрүүл мэндийн болон боловсролын салбарын хуульд заасан шалгуур, нөхцөлд хамаарах төрийн үйлчилгээний албан хаагч болон төрийн тусгай албан хаагчаас бусад энэ журмын үйлчлэлд хамаарах төрийн албан хаагч нийтдээ 5 жил, үүнээс

сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүснэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилтанд олгосон тэтгэмжийн зардлыг Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу анхан шатны баримтыг дахин хянаж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах

2. Шилэн дансны цахим сайтад нийт 493,629.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 454,325.6 мянган төгрөгийн 145 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39,304.4 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 4 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

3. Тус байгууллага нь улсын төсвөөс 446,203.5 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 444,107.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 2,096.2 мянган төгрөг буюу төсвийн 4.7 хувийг, ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 22,194.2 мянган төгрөгөөр, тодотголоор 19,946.1 мянган төгрөгөөр буруулан баталж зардлын 20 хувийг нэмнэхээс 2,248.1 мянган төгрөг буюу 10 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	6	164,724.7	1	628.6	1	1,313.1	1	139,025.0	3	23,758.0

оОо